



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/603

Есөвбулаг

Ажлын хэсэг байгуулж,  
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2. дахь хэсэг, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмын 3.7, 3.7.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 4.2.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 73 дугаар тогтоолоор баталсан "Үндэсний аюулгүй байдлын үйл ажиллагаанд баримтлах аймгийн бодлого"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



хорооны дарга

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

"Алтай-Улиастай" ЭХСТӨХК-ийн захирал

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Нийгмийн даатгалын хэлтсийн дарга

Гадаадын иргэн харьяатын газрын баруун бүс дэх газрын

аймаг дахь ажилтан

"Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын захирал

Авто тээврийн төвийн дарга

Говь-Алтай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний

хэлтсийн дарга

Аймгийн Цахилгаан холбооны газрын дарга

"Мэдээлэл холбоо сүүлжээ" ТӨХК-ийн аймгийн

салбарын дарга


Аймгийн "Алтай" нисэх буудлын газрын дарга

"Тайшир гуулин" УЦС захирал

**Нарийн бичгийн дарга:** Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

--- оОо ---

Аймгийн Засаг даргын ... оны  
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙГ  
МЭДЭЭ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЖУРАМ  
Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын Ажлын хэсэг /цаашид "Ажлын хэсэг" гэх/ нь нутаг дэвсгэрийнхээ хүрээнд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох бусад хууль, тогтоомж, орон нутгийн бодлогын хэрэгжилтийг хангана.

1.2. Ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал хариуцсан албан тушаалтан, өдөр тутмын болон шуурхай мэдээ хариуцсан албан тушаалтны эрхэлдэг үндсэн албан тушаалын тодорхойлолтод Ажлын хэсгийн хариуцах ажлыг тусгаж, эрх бүхий этгээдээр баталгаажуулсан байна.

1.3. Ажлын хэсэг нь өөрийн үйл ажиллагааг аливаа байгууллага, албан тушаалтнаас хараат бус, бие даасан байдлаар явуулна.

**Хоёр. Ажлын хэсгийн эрх, үүрэг**

2.1. Орон нутгийн хэмжээнд төрийн бодлого, хууль, тогтоомжид нийцүүлэн үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих;

2.2. Орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах;

2.3. Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, арилгахад орон нутгийн удирдлагад дэмжлэг үзүүлэх;

2.4. Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зардлыг улсын болон орон нутгийн төсөв, төсвөөс гадуурх хөрөнгийн эх үүсвэрээр шийдвэрлүүлэх зорилгоор холбогдох байгууллагад санал хүсэлт тавих;

**Гурав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүний эрх, үүрэг**

3.1. Ажлын хэсгийн ахлагчийн эрх, үүрэг:

3.1.1. Бодлогыг хэрэгжүүлэх болон ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.1.2. Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоох, хөтөлбөрийг батлах, хуралдааныг даргалах, шийдвэр гаргах;

3.1.3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ирүүлсэн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.4. Харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд Үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа тухай илтгэлийг тавих;

3.1.5. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан товлосон хугацаанаас өмнө Ажлын хэсгийг хуралдааны товыг зарлаж, шуурхай хуралдуулах;

3.1.6. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг батлах;

### **3.2 Ажлын хэсгийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг**

3.2.1. Ажлын хэсгийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Ажлын хэсгийн ахлагчид тухай бүрд нь тусалж ажиллах;

3.2.2. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

3.2.3. Шуурхай мэдээ, яаралтай мэдээ, хагас жилийн мэдээ, жилийн эцсийн мэдээ, тайлан, илтгэлийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Ажлын албанд хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.4. Ажлын хэсгийн ахлагчийн эзгүй байх үед Ажлын хэсгийн үйл ажиллагааг чиглүүлэн зохион байгуулах;

3.2.5. Хагас жил болон жилийн эцсийн тайлан, мэдээ, үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа тухай илтгэлийг боловсруулж, Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэх;

3.2.6. Үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал хариуцсан өдөр тутмын болон шуурхай мэдээ хариуцсан албан тушаалтан нарын үндсэн үүрэгт ажлыг нь цэлгардуулалгүйгээр удирдан чиглүүлэх;

### **3.3 Ажлын хэсгийн гишүүний эрх, үүрэг**

3.3.1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Ажлын хэсгийн ахлагчаас өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх, хариу мэдээлэх, тайлагнах;

3.3.2. Өөрийн байгууллагын хариуцсан ажлын чиглэлээр Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаа, нөхцөл байдлын талаар Ажлын хэсэгт дүгнэлт, санал бүхий мэдээлэл танилцуулах;

3.3.3. Үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж буй тухай илтгэлийг боловсруулах ажилд оролцох;

**Дөрөв. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг зохион байгуулах хариуцсан нэгж, ажилтан түүний эрх, үүрэг**

4.1. Энэ журмын 1.2-т заасан Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг зохион байгуулах нэгж нь аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын ажил хариуцсан офицер, Хууль эрх зүйн хэлтсийн ажил хариуцсан мэргэжилтэн, байгууллагын төрийн болон албаны нууц хариуцсан ажилтан, аймгийн Тагнуулын хэлтсийн ажилтан гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

4.2. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг зохион байгуулах ажил хариуцсан нэгж, ажилтан нь ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн даргад шууд захирагдана.

**4.3. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг зохион байгуулах ажлыг хариуцсан нэгж нь дараах нийтлэг эрх үүрэгтэй байна.**

4.3. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг зохион байгуулах ажлыг хариуцсан нэгж нь дараах нийтлэг эрх үүрэгтэй.

4.3.1. Байгууллагын удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, хууль тогтоомжийн хэрэгжилт, мэдээ судалгаатай холбоотойгоор холбогдох байгууллагыг шалгаж, танилцах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах хугацаатай үүрэг чиглэлийг өгөх.

4.3.2. Орон нутагт Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, төрийн болон албаны нууцтай холбогдох хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулахад ажлын хэсгийг ахлагчид дэмжлэг үзүүлж, бусад байгууллагуудад хууль тогтоомжийг сурталчлах талаар сургалт зохион байгуулах.

4.3.3. Холбогдох үүрэг хүлээсэн байгууллага албан тушаалтнаас тогтоосон хугацаанд ирүүлсэн мэдээ тайлан, бусад шаардлагатай мэдээллийн талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх.

4.4. Өдөр тутмын болон шуурхай мэдээ хариуцсан Цэргийн штабын ажил хариуцсан офицерын эрх, үүрэг

4.4.1. Аймаг, орон нутагт болсон онцгой үйл явдал, цаг үеийн нөхцөл байдлын тухай шуурхай мэдээ болон яаралтай мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны шуурхай мэдээ хариуцсан референтэд хоногт 2 удаа мэдээлэх

4.4.2. Төрийн байгууллага, албан тушаалтнаас өдөр тутмын нөхцөл байдлын мэдээг гаргуулан авах.

4.4.3. Холбогдох мэдээ тайланг нэгтгэн боловсруулж, удирдах албан тушаалтанд танилцуулж, зөвшөөрсний үндсэн дээр зохих журмын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэх

4.4.4. Хариуцсан ажлын чиглэлээр бүртгэл судалгааг хөтлөх.

**4.5. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал хариуцсан Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтний эрх, үүрэг**

4.5.1. Байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн мэдээ, тайланг Ажлын хэсгийн ахлагч, Нарийн бичгийн даргад танилцуулах;

4.5.2. Холбогдох мэдээ, тайланг нэгтгэн боловсруулж, удирдах албан тушаалтанд танилцуулж, зөвшөөрсний үндсэн дээр зохих журмын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Ажлын албанд хүргүүлэх;

4.5.3. Үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар байгууллага, албан тушаалтныг холбон ажиллах;

4.5.4. Ажлын хэсгийн болон төрийн байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн мэдээ, тайлан, судалгааны баримт бичгийг нэгтгэн боловсруулах, бүртгэл хөтлөх;

4.5.5. Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж, албажуулах;

#### **4.6. Байгууллагын төрийн албаны нууц хариуцсан ажилтны эрх, үүрэг**

4.6.1. Төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын хэрэгжилтийг хангуулах.

4.6.2. Нууцтай холбогдох мэдээ, тайланг нэгтгэн боловсруулж, удирдах албан тушаалтанд танилцуулж, зөвшөөрсний үндсэн дээр зохих журмын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэх

#### **4.7. Тагнуулын хэлтсийн ажилтан түүний эрх, үүрэг**

4.7.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй орон нутгийн байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох, Төрийн болон албаны нууцын журмын хэрэгжилтийг хангуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангах

4.7.2. Журмын 4.7.1-т заасан асуудлаар Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг зохион байгуулах нэгжээр дамжуулж, ажлын хэсэгт санал хүсэлт тавих, явуулж буй үйл ажиллагаанд хяналт тавих.

4.7.3. Үндэсний аюулгүй байдал, төрийн болон албаны нууцын асуудлаар урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, байгууллага албан тушаалтанд ажлын хэсгийн ахлагчаар чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавих.

#### **Тав . Ажлын хэсгийн үйл ажиллагааны талаар**

5.1 Ажлын хэсэг нь хагас жил тутамд хуралдах бөгөөд эхний хагас жилийн хурлыг 6 дугаар сарын 15-аас өмнө, жилийн эцсийн хурлыг 12 дугаар сарын 10-аас өмнө хуралдана.

5.2. Ажлын хэсэг хэлэлцэх асуудалтай холбогдуулан хаалттай хуралдаж болно.

5.3 Ажлын хэсгийн ахлагч, Нарийн бичгийн дарга нар Ажлын хэсгийн хуралдаанд оролцох гишүүдийн тоог хязгаарлах, эсвэл өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулахыг хэлэлцэх асуудлыг хамаарах гишүүний саналыг үндэслэн зөвшилцөж шийдвэрлэнэ.

#### **Зургаа. Ажлын хэсгийг мэдээллээр хангах тогтолцоо**

6.1. Ажлын хэсгийг мэдээллээр хангах үүргийг орон нутаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй төрийн болон төрийн бусад байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж хүлээнэ.

6.2 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд Ажлын хэсгийн шийдвэрийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг тогтоосон хугацаанд хариу мэдээлэх үүрэгтэй.

6.3 Ажлын хэсэг нь шаардлагатай бол үндэсний ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдлыг хөндсөн тодорхой асуудлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагаас шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулан авна.

6.4.Яаралтай мэдээг Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалт хариуцсан мэргэжилтэн холбогдох утсаар эсвэл биечлэн дамжуулна.

6.5.Аймаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй байгууллага, албан тушаалтан эрхэлсэн ажлын хүрээнд өдөр тутмын нөхцөл байдлын талаар Цэргийн штабт мэдээлнэ.

6.6.Төрийн байгууллага, албан тушаалтнууд ажлын хэсэгт ирүүлэх мэдээг хагас жилээр 06 дугаар сарын 15-ны дотор, жилийн эцсийн тайлан, мэдээг 12 дугаар сарын 01-ний дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

6.7. Төрийн байгууллагууд энэхүү журмын хавсралтад заасан мэдээллийг Ажлын хэсэгт бичгээр ирүүлнэ. Мэдээллийг эрх бүхий албан тушаалтны гарын үсэг бүхий албан тоотоор шуудангаар, биечлэн эсвэл цахим шуудангаар хүргүүлнэ.

6.8. Цаасаар хүргүүлж байгаа мэдээллийг цахим хэлбэрээр /Flash, CD гэх мэт/ хавсаргасан байна. Ингэхдээ мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээг авсан байна.

6.9. Мэдээ, мэдээлэл ирүүлэхэд энэхүү журамд тусгаагүй бусад асуудлыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.



Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын  
зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах  
журмын хавсралт

АЖЛЫН ХЭСЭГТ ИРҮҮЛЭХ МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэрс	Ирүүлэх мэдээ	Мэдээний ангилал	Хугацаа
1.	Аймгийн ИТХ-н Ажлын алба	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллага, сүм хийдийн талаарх мэдээ	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
		Улс төрийн сонгууль хараат бусаар, хэвийн явагдах нөхцөлийг хангах, гарч буй сөрөг үзэгдэлд хариу арга хэмжээ авч ажиллана.	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
2.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтэс	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулахаас сэргийлэх, нийтлэлийн бодлого нь үндэсний үнэт зүйлийг дэмжих, сурталчлахад чиглүүлэн ажиллана.	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
		Гадаадын төлөөлөгчидтэй хийсэн уулзалт, ярианы тэмдэглэл, байгуулсан хэлэлцээр, гэрээ, санамж бичиг	Тэмдэглэлийн хуулбар	Тухай бүр
		Төрийн болон орон нутгийн эрх мэдлийг Үндсэн хуулийн бус аргаар авахыг завдсан аливаа оролдлого, үйл ажиллагаа, хууль тогтоомж зөрчсөн, гажуудуулсны улмаас ард иргэдийн бухимдал үүссэн болон үүсэж болох нөхцөл байдал бий болж болзошгүй үед хууль, хүчний байгууллагуудын оролцоотойгоор таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
		Орон нутгийн өөрөө удирдах болон төр, захиргааны байгууллага иргэдэд ил тод, хариуцлагатай үйлчилж байгаа байдал, гарч байгаа сөрөг үзэгдэл, цахим засаглалын хүртээмжтэй байдал	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
3.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс	Хүний эрхийн төлөв байдлын тайлан	Танилцуулах тойм мэдээ	Жил бүр
		Нутаг дэвсгэрийн хэмжээнд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төрийн бүх шатны байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн хүрээнд тэдний оролцоотойгоор	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам

		эрчимжүүлж, аалигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлнэ		
		Үндэсний агуулгүй байдлын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийн талаар	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
4.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын төлөвлөлт хэрэгжилтийн талаар	Танилцуулах мэдээ	Улирал бүр
		Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, олгож буй зээл, түүний үр ашиг, эргэн төлөлтийн тухай мэдээ, судалгаа	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Хайгуулын томоохон төслүүдийн талаарх мэдээ	Танилцуулах мэдээ	Улирал бүр
		Химийн хортой, мансууруулах, тэсэрч дэлбэрэх бодис болон тасалгээний хэрэгслийн импорт, үйлдвэрлэл, хадгалалт, ашиглалтын тухай	Танилцуулах мэдээ	Сар бүр
		Ашигт малтмалын хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, уурхайн талбайн нөхөн сэргээлтийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Төв суурин газрын ундны усны хангамж, чанарт шинжилгээт хяналт хийж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
		Хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын саванд хадгалах, тээвэрлэх, худалдаалах, хаяг, шошгын стандартыг мөрдүүлэхэд хяналт тавьж ажиллана	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
		Аймгийн хэмжээнд атаршсан талбайг үр тариа, жимс, жимсгэнэ, малын тэжээл тариалах чиглэлээр эдийн засгийн эргэлтэд оруулна	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
5.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс	Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох болон иргэнээс байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Аймагт үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллагын тайлан мэдээ, үйл ажиллагааг ил тод болгож, санхүүгийн сахилга бат, татварын тогтолцоо хэрхэн хангаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгөх, мэдээллийн нэгдсэн сантай болно	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
6.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс	Түүхийн дурсгалт, соёлын өвийн хадгалалт хамгаалалтын талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Цус ойртолтын хор уршиг, үр дагаврыг ойлгуулах, удам угсаагаа таньж мэдэх, монгол удмын сангаа цэвэр ариун	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам

		байлгах соёл, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.		
7.	Цэргийн штаб	Батлан хамгаалах талаарх бодлого үйл ажиллагааг иргэдэд сурталчилсан тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Эх оронч үзэл, хүмүүжил, төлөвшүүлэх сэтгэлгээ чиглэлээр зохиож буй ажлын тайлан	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Аймаг болон сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу томилгоот нэгжүүдийг байгуулж, иргэдийг орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд сургаж бэлтгэнэ.	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
		НҮБ-ын энхийг дэмжих болон олон улсын бусад цэргийн ажиллагаанд аймгийн нутаг дэвсгэрт байрлах төрийн цэргийн болон хууль хүчний байгууллагын бие бүрэлдэхүүний оролцоог хангах, тэдний мэргэжлийн ур чадварыг иргэдийн аюулгүй байдлыг хангахад чиглүүлнэ.	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
8.	Аймгийн Прокурорын газар	Төрийн албан хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн мэдээ	Танилцуулах тойм	Тухай бүр Жилдээ
		Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байдлад хяналт тавьсан тухай мэдээлэл	Танилцуулах тойм	Хагас Жил тутам
9.	Аймгийн Шүүхийн тамгын газар	Бүх шатны шүүхээс эрүүгийн, иргэний, захиргааны хэргийн шийдвэрлэсэн шүүн таслах ажлын тухай мэдээ	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
10.	Тагнуулын хэлтэс	Аймаг орон нутаг үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагааны нөхцөл байдлын мэдээ, хүчин зүйлс, тэдгээрээс сэргэмжлүүлэх арга хэмжээний санал	Шуурхай Танилцуулах мэдээ	Тухай бүр
		Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын мэдээ	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Кибер аюулгүй байдлын орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллана	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
11.	Цагдаагийн газар	Орон нутгийн хэмжээнд үйлдэгдсэн эрүүгийн болон хэв журмын эсрэг гэмт хэргийн тоо тэдгээрийн төрөл, хүн амины санаатай болон онц хүнд, зохион байгуулалтай гэмт хэргийн талаарх мэдээ	Шуурхай	Тухай бүр
		Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын тухай өдөр тутмын мэдээ	Шуурхай	7 хоног, сар, жил бүр
		Эзэн холбогдогч нь	Танилцуулах	Улирал бүр

		тогтоогдоогүй хэргийг илрүүлсэн ажлын товч тайлан	мэдээ	
		Эрэн сурвалжлагдаж буй хүн, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, химийн цацраг идэвхт бодисыг олж тогтоосон, эдгээртэй холбоотой гэмт хэргийн мэдээ тайлан	Танилцуулах мэдээ	Тухай бүр
		Улсын онц чухал объектын хамгаалалтын нөхцөл байдлын талаар	Танилцуулах мэдээ	Сар бүр
		Тэсэрч, дэлбэрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт таах хуулийн хэрэгжилтийн талаар	Танилцуулах мэдээ	Сар бүр
12.	Шүүх шинжилгээний хэлтэс	Шүүх шинжилгээний ажлын тайлан, тулгамдсан асуудал	Тайлан мэдээ	Хагас жил тутам
		Улсын хилийн хариуцсан хэсгийн цагийн байдал, хилийн болон хил орчмын зөрчлийн мэдээ	Танилцуулах тойм мэдээ	Улирал бүр
13.	Хилийн цэргийн 0214 анги	Иргэдэд эх оронч үзэл, хүмүүжил, төлөвшүүлэх сэтгэлгээ чиглэлээр зохиож буй ажлын тайлан	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Цаг үеийн нөхцөл байдлын тухай	Шуурхай Танилцуулах мэдээ	Тухай бүр
		Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулсан тухай мэдээ	Тайлан мэдээ	Хагас жил тутам
14.	Онцгой байдлын газар	Аюулт үзэгдэл, үйлдвэрлэлийн ослын тухай	Шуурхай	Тухай бүр
		Аюулт үзэгдэл зэрэг байгалийн гамшиг, түүний хор уршиг, нийгэм, эдийн засагт учруулсан хохирлын тухай	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
		Хүн амын шилжилт, хөдөлгөөний танилцуулга	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
15.	Улсын бүртгэлийн хэлтэс	Хүн амын төрөлтийн өсөлт, бууралтын тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Шашны байгууллага, сүм хийд, төрийн бус байгууллагуудын тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Татварын төлөвлөгөөний биелэлт /нэгдсэн болон салбар бүрээр/	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Байгаль орчны төлөв байдал, экосистемийн өөрчлөлт, хүн, малын эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, эрсдэл, тулгамдсан асуудал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан үр дүн, усны нөөц баялаг, хомсдол,	Танилцуулах тойм	Хагас жил тутам
17.	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Байгалийн нөөц ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн тухай	Танилцуулах	Хагас жил тутам
		Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, хуурайшилтын өнөөгийн болон хэтийн төлөв, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогын	Танилцуулах	Хагас жил тутам

		хэрэгжилтийн талаар Ховор, нэн ховор устах аюулд орсон амьтан, ургамлын төрөл зүйлийн хамгаалал, өсгөн үржүүлэлт, тэдгээрийн тооллогын талаар	Танилцуулах	Хагас жил тутам
		Хүн амын ундны усны хангамж, эрүүл ахуйн чанар, үйлдвэрлэлийн усны хангамж, боломжит нөөцийн байдлын талаар	Танилцуулах	Хагас жил тутам
		Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, эдийн засагт эзэлж буй хувь хэмжээ, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, аялал жуулчлалын байгууллагын талаар	Танилцуулах	Хагас жил тутам
		Химийн хортой, мансууруулах, тэсэрч дэлбэрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн импорт, үйлдвэрлэл, хадгалалт, ашиглалтын тухай	Танилцуулах мэдээ	Улирал бүр
		Тэсэрч, дэлбэрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих хуулийн хэрэгжилтийн талаар	Танилцуулах мэдээ	Улирал бүр
		Ашигт малтмалын хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, уурхайн талбайн нөхөн сэргээлтийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Амьдрах орчны аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Газрын нэгдмэл сан, ангилал тус бүрийн талбай, газрын төлөв байдлын мэдээ, судалгаа зураглал, / зурган мэдээний хамт/	Танилцуулах	Тухай бүр
		Барилгын салбарт улсын төсөв, гадаадын болон дотоодын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, тэдгээрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан болон ажлын гүйцэтгэлийн мэдээ, судалгаа	Танилцуулах тойм	Хагас жил тутам
18.	Газрын харилцаа хот барилга, байгуулалтын газар	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тогтоосон хугацаа бүрт шинэчлэн боловсруулж батлуулна	Танилцуулах тойм	Хагас жил тутам
		Аймаг, сум болон хил залгаа бусад аймаг, сумдын хоорондын хилийн цэсийн маргаантай асуудлыг мэргэжлийн байгууллагуудаар шийдвэрлүүлэх, хилийн нарийвчилсан цэсийг нутгийн иргэдэд таниулах ажлыг зохион байгуулна	Танилцуулах тойм	Хагас жил тутам

19.	Боловсрол, шинжлэх ухааны газар	Эх оронч үзэл, хүмүүжил, төлөвшүүлэх сэтгэлгээний чиглэлээр зохиож буй ажлын тайлан	Танилцуулах тойм	Хагас жил тутам
		Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон Ерөнхий боловсролын сургуульд хамран суралцагчдын тоог нэмэгдүүлэх, хүүхэд багачуудыг амар тайван, аюулгүй нөхцөлд сурч, хүмүүжих орчин нөхцөлийг бүрдүүлнэ	Танилцуулах тойм	Хагас жил тутам
		Аймгийн боловсролын салбар дахь олон улсын стандартын хэрэгжилт, их дээд сургууль, Ерөнхий боловсролын байгууллагын уялдаа холбоог сайжруулах, хүний хөгжлийг дээшлүүлэх үндэсний эрх ашгийн хүрээнд хийгдэж байгаа ажлыг эрчимжүүлнэ	Танилцуулах тойм	Хагас жил тутам
		Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт явцын тухай мэдээ тайлан	Танилцуулах тойм	Хагас жил тутам
20.	Соёл урлагийн газар	Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншил, төв халхын биет болон биет бус өв, нутгийн онцлогтой язгуур өвийг хамгаалах, өвлөн уламжлуулах, бэхэрхах үзэлд төлөвшүүлэх, сурталчлан түгээн дэлгэрүүлэх бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Танилцуулах	Хагас жил тутам
		Соёлын чиглэлээр ЮНЕСКО-ийн конвенциудад нэгдсэн улс орнуудтай соёлын олон төрөл зүйлээр харилцаа холбоог өргөжүүлэх, дипломат төлөөллөөр дамжуулан түүх, төв халхын болон нутгийн онцлогтой өв соёлыг Олон улс, дэлхий дахинаа сурталчлах ажлыг хэрэгжүүлнэ	Танилцуулах	Хагас жил тутам
21.	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Хүн амын хүнсний бодит хэрэглээ, хангамжийн болон чанар, эрүүл ахуйн төлөв байдал, хүнсний нэр төрөл, найрлага, шим тэжээлийн зохистой харьцаа, цаашид авах арга хэмжээний тухай мэдээ	Танилцуулах	Хагас жил тутам
		Мал аж ахуйн бодлогын хэрэгжилт, малын тоо, өсөл, хорогдол, үржлийн бодлого, сүргийн бүтцийн тухай мэдээ	Танилцуулах	Хагас жил тутам
		Генийн инженерчлэлийн үр дүнд бий болсон хувиргасан амьд организм буюу генийн өөрчлөлттэй импортын бүтээгдэхүүний хэрэглээг багасгах талаар ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын	Танилцуулах	Хагас жил тутам

		байгууллагаар дамжуулан нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ		
		Бэлчээр ашиглалт, бэлчээрийн усан хангамжийн талаар	Танилцуулах	Хагас жил тутам
		Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн мэдээ	Танилцуулах	Хагас жил тутам
		Хүн амын өвчлөл, эндэгдлийн мэдээ	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Төрөлт ойртолт, түүний хүн амд эзлэх зохистой харьцааны алдагдал, архи, мансууруулах болон сэтгэцэд хүчтэй нөлөөлөх бодис хэрэглэх, донтох, эмгэг сэтгэцийн эмгэг, зан үйл, оюуны хомсдолтой хүмүүсийн мэдээ судалгаа	Танилцуулах	Хагас жил тутам
		Шинээр болон сэргэж тархаж буй халдварын болзошгүй аюулаас сэргийлэх, хариу арга хэмжээ, халдвар, хордлогын өвчлөл, эрсдэлийн тухай	Шуурхай мэдээ Танилцуулах	Тухай бүр Жил бүр
		Төвлөлийн болон тархвар зүйн вакцин, биобэлдмэлийн нөөцийн хүрэлцээ, хангамж, устгалын талаар	Шуурхай мэдээ Танилцуулах	Тухай бүр Жил бүр
		Цэргийн насны иргэдийн эрүүл мэндийн төлөв байдлын тухай	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Халдварт бус өвчний эрт илрүүлээгийн хамрагдалт, хянах, эмчлэх, үйл ажиллагааны үзүүлэлтийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Эрүүл мэндийн салбарын эмчилгээ, оношилгооны чанарын хяналтын үйл ажиллагааны тухай	Танилцуулах Мэдээ Тайлан мэдээ	Хагас жил тутам
		Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж буй тоног төхөөрөмж, аппаратын мэдээлэл шаардагдаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл	Танилцуулах Мэдээ Тайлан мэдээ	Хагас жил тутам
		Эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлыг бүх шатны боловсролын байгууллага, хэвлэл мэдээллээр дамжуулан хэрэгжүүлнэ.	Танилцуулах Мэдээ Тайлан мэдээ	Хагас жил тутам
		Гаалийн статистикийн мэдээ	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Гаалийн хяналтаар илрүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ	Танилцуулах мэдээ	Тухай бүр
		Монгол Улсаас экспортолсон, импортолсон бүтээгдэхүүн /нэр төрөл бүрээр/	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Түүх соёлын хосгүй үнэт зүйлийг хууль бусаар гадаадад гаргаж буй тохиолдлын талаар	Танилцуулах мэдээ	Тухай бүр
		Гадаадын иргэдийн холбогдсон гэмт хэрэг, зөрчлийн мэдээ	Шуурхай	Тухай бүр
22.	Эрүүл мэндийн газар			
23.	Гаалийн хороо			
24.	Гадаадын харьяатын иргэн газрын			

Говь-Алтай аймаг дахь ажилтан	болон албадан гаргасан иргэдийн талаар		
	Гадаадын болон олон улсын төрийн бус байгууллагуудын төлөөлөгч нарын газрын тоо, байршил, судалгааны талаар	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
	Монгол Улсад ажил үйлчилгээ явуулж байгаа гадаадын иргэдийн судалгаа	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
	Харьяалалгүй хүмүүсийн мэдээлэл	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
25. Ус, цаг, уур орчны шинжилгээний төв	Байгаль, цаг агаарын онц аюултай гамшигт үзэгдлийн тухай	Шуурхай	Тухай бүр
26. Мал эмнэлгийн газар	Малын халдварт өвчний цагийн байдлын тухай	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
	Малын эмнэлгийн талаар баримталж буй бодлогын хэрэгжилт, малын тоо, өсөлт, хорогдол, үржлийн бодлого, сүргийн бүтцийн тухай мэдээ	Танилцуулах	Хагас жил тутам
	Малын эрүүл мэнд, малын халдварт өвчний гаралт, тархалт, тандалт судалгааны талаар /танилцуулах мэдээг сүүлийн 10 жилийн харьцуулсан судалгааны дүн, эрсдэлийн түвшингээр/	Шуурхай Танилцуулах	Хагас жил тутам
27. Статистикийн хэлтэс	Сар, улирал, жилийн статистик мэдээ, мэдээлэл тайлан	Танилцуулах тойм мэдээ	Хагас жил тутам
	Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үнэ ханш, статистикийн үзүүлэлт	Танилцуулах мэдээ	Улирал тутам
28. "Алтай-Улиастай" ЭХСТӨХК	Түлш эрчим хүчний салбарын эрсдэлийн үнэлгээ, аюулгүй байдлын үзүүлэлтүүдийн төлөв байдлын тухай мэдээ, судалгаа	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
29. "Ундарга-Алтай" ОНБААТУ-ийн газар	Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийн тухай /зураглал, зурган мэдээллийн хамт/	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
30. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар	Хүн амын амьжиргааны түвшний судалгаа /хувиар/	Танилцуулах	Улирал бүр
	Хөдөлмөрлөх хүчний хангамж, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, дадлагын болон ажлын байраар хангагдсан төлөв байдлын мэдээ, судалгааны талаар	Танилцуулах	Хагас жил тутам
	Хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийн бүтэц, салбар бүрээр, хүйс, насны ангиллын мэдээ	Танилцуулах	Улирал бүр
	Хөдөлмөр эрхлэлтийн байдлын судалгаа	Танилцуулах	Улирал бүр
	Аймгийн нийт иргэд, өрх гэр бүлийн амьдралын үндсэн хэрэгцээ хангагдаж байгаа эсэх, тэдний ажлын байрны хангалт, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, ядуурлыг	Танилцуулах	Улирал бүр



		бууруулах асуудлыг чиглэл болгон ажиллана		
		Нийгмийн халамжийн үйл ажиллагааны мэдээ	Танилцуулах	Улирал бүр
		Асрамжийн үйлчилгээнд байгаа, хүнд нөхцөлтэй 18 хүртэлх насны хүүхдийн тухай мэдээ, судалгаа	Танилцуулах	Хагас жил тутам
31.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Төрөөс хэрэгжүүлж буй гэр бүлийн хөгжил, тогтвортой байдлыг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах болон хүүхдийн эрх, нийгмийн дэмжих бодлогын хэрэгжилтийн тухай	Танилцуулах, Тайлан мэдээ	Хагас жил тутам
32.	Төрийн аудитын газар	Хяналт шалгалтаар илрүүлсэн, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд шууд болон шууд бусаар хохирол учруулж байгаа, учруулж болзошгүй эрсдэлт үйл явдлын тухай	Танилцуулах мэдээ	Тухай бүр
33.	Монгол банкны аймаг дахь салбар	Төрийн мөнгөн тэмдэгтийн үнэ цэнийн талаар болон иргэдийн санхүүгийн боловсролын түвшин	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
34.	Нийгмийн даатгалын хэлтэс	Нийгмийн даатгалын сангийн мэдээ	Танилцуулах тойм	Хагас жил тутам
35.	Авто тээврийн төв	Зам тээврийн салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, эрсдэлт хүчин зүйл	Танилцуулах тойм	Хагас жил тутам
36.	Говь-Алтай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Мэдээлэл холбоо сүлжээ" ТӨХК-н Говь-Алтай аймгийн салбар	Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдал, илэрсэн зөрчлийн талаар	Танилцуулах мэдээ	Хагас жил тутам
		Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө хийсэн ажлын талаар	Тайлан мэдээ	Хагас жил тутам
37.	Говь-Алтай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Цахилгаан холбооны газар	Мэдээллийн аюулгүй байдлын хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө, хөтөлбөр, хийсэн ажлын талаар	Тайлан мэдээ	Улирал бүр
38.	Алтай нисэх буудал	Нислэгтэй холбоотой цаг үеийн нөхцөл байдлын мэдээ	Танилцуулах мэдээ	Сар бүр
39.	Тайшир-Гуудин УЦС ХХК	Эрчим хүчний аюулгүй байдлын талаар	Танилцуулах мэдээ	Тухай бүр
40.	Төрийн байгууллагууд	Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалт, үндэсний аюулгүй байдал, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулсан харэг зөрчлийн тухай	Танилцуулах мэдээ	Тухай бүр